24. (Рахевилц, 1972) Index to the secret history of the mongols by Igor de Rachewiltz, Bloomington,1972.
25. Б. Л. Рифтин. От мифа к роману. Эволюция изображения персонажа в китайской литературе. М., 1979.
26. (Саган Сэцэн, 1960). Sayang sečen, erdeni-yin tobči,M.H., Tom.I,Fasc.I, Ulanvan-bavatur, 1960.
27. (Сарат Чандра Дас, 1973) A.Tibetan-English dictionary by Sarat Chandra Das.Delhi, 1973.
28. (Суматирадна, 1959) Sumatiratna, bod hor-kyi brda yig minchig don-gsum gsal-bar byed-pa mun sel skron me "Corpus sciptorum Mongolorum", Tom.VII, 1959.
29. (Токарев, Т. 1, 1980) Мифы народов мира, том первый (А-К) главый редактор Токарев,М. 1980.
30. (Токарев, Т. П. 1982) Мифы народов мира, том второй, (М-Я) главный редактор Токарев, М., 1982.
31. (Хэниш, 1941) E.Haenisch, Die geheime Geschichte der Mongolen, Leipzig, 1941.
32. Я. Цэвэл, Монгол хэлний товч тайлбар толь, УБ., 1966.
33. (Цэнд гун) Yuwan ulus-un niyuca teüke,nigeduger debter.

(Государственная публичная библиотека МНР. под шифром: 9(5+7. 3+51) Уи 141)

34. К. М. Черемисов, Бурятско-русский словарь, М. , 1973.
35. И. Чистохин Сохор Ноин (Местное предание Тункинских бурят) в сб: "Известия Вост. сиб. отд. русск. Геогр. об-ва" 1895 т. XXV1, №1-3
36. (Шагдар. 1957). Алтан товч п хэвлэлд бэлтгэсэн Ц. Шагдар, УБ. , 1957.
37. (Шагж. П) erikŭi-e kilber bolγan jokiyaγsan mongγol ŭgen-ŭ tayilburi čindamani-yin erike kemegdekŭ eče ba,qa-yin ayimaγ. ded debter.

(Государственная Публичная Библиотека МНР. Рукописный фонд)

38. Я. Шмидт, Тибетско-русский словарь, СПБ. , 1843.

Монгол-Зөвлөлтийн армийн усгүй элсэн цөл, хяналны бартаат нуруу зэрэг байгалийн бэрхшээлийг эр зориг, сэтгэл зүйн их тэвчээрээр даван ирснийг өгүүлнэ. Мөн их дайныг цэрэг улс төрийн мэргэжил боловсролтой эх оронч өндөр үзэл уламсартай Зөвлөлт-Монголын цэргийн нэрт зүтгэлтнүүд удирдаж байгааг харуулсан байна. Эдгээр нь киноны тухэн тал юм. Гэтэл киноны уран сайхны тал нь бас ч унэмшилтэй, сэтгэл догдлом болжээ. Ялангуяа энх тунх цаг ирлээ гэж баярлаж байсан хошууч Матвеев сувилагч бүсгүй Люба гээд олон орос хүмүүс Москва, Белоруссын буудалд зогсолгүй ахин тулалдаанд орохоор дорно зүг рүү явж байгаа, Улаан талбайд болсон ялалтын парадыг радиогоор сонсож тэр их баярыг сэтгэл дүүрэн тэмдэглэж байгаа хэсэг бол энх тунх амьдралд дуртай ялалтыг хүсэн хүлээж тулалдаж явсан хүмүүсийн сэтгэлийг үзүүлсэн гайхамшигтай уран дүрслэл болсон ажээ. Энэ киног баримт уран сайхны талаас жигд болов - руулж чадсан тул түүхэн унэнийг ард түмэнд танин мэдүүлж ингэснээрээ ахмад үеийнхний алдрыг мөнхжүүлж залуу үеийг энх тайвны үйлст чин унэнч интернациональч үзэл санаагаар хүмүүжүүлэхэд их үүрэг гүйцэтгэсэн нь лавтай. Иймч учраас Зөвлөлтийн киноны зүтгэлтнүүд "Энэ кино бол дэлхийн хоёрдугаар дайны дорно дахины голомтыг асар их гарз хохирол үзэж байж унтраасан түүхэн том үйл явдлын баатарлаг тууль юм"(3. 248) гэж унэлжээ. М. Чимэд-Осорын бүтээсэн "Тамирын оюун" кинонд ч гэсэн дайны хүнд бэрх үед сурч хүмүүжиж ажиллаж амьдарч байгаа хүүхэд багачууд, багш, эцэг эхчүүдийн дүрийг уран сайхнаар аятайхан харуулсан хэсэг олон бий. Их тэмцэл ялалтын тухай сэдвийг Монголын орчин үеийн уран зохиолд хэрхэн дүрсэлснийг товч төдий судлан шинжлэхэд дорхи хэдэн дүгнэлт хийж болох байна.

1. Энэ сэдэв Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдлын тухай сэдэвт уран зохиолд зонхилох байр эзэлж байна. Энэ чанараараа залуу үеийг эх оронч интернационалист үзлээр хүмүүжүүлэхэд ихээхэн нөлөө үзүүлэх болно.

2. Яруу найргийн хөгжилд үлэмжхэн нөлөө үзүүлж уран санааг нээх хүрц дүрслэлээр дүрийг тодруулах боломжийг нэмэгдүүлсэн байна.

3. Монголын утга зохиолд (Л. Түдэвийн бичсэнчлэн) интернационалчийн дүрийг бүтээхэд энэ сэдэв чухал үүрэг гүйцэтгэсэн байна.

НОМ ЗОХИОЛ

1. МАХН-ын товч түүх УБ. 1967
2. БНМАУ-ын түүх гуравдугаар боть (нэн шинэ үе) УБ 1969
3. Үнэн сонин 1981 №248
4. Л. К. Герасимович (литература МНР. Л. 1965.)
5. Л. Түдэв (Национальной и интернациональной в Монгольской литературе) М. 1982.
6. Л. Цэнд (Оршил, С. Удвал Тууж өгүүллэг, УБ. 1974

РЕЗЮМЕ

Статья, посвящена изучению жанров монгольской художественной литературы, в которых отражали дружбу монгольского и советского народов в период Великой отечественный Войны.

В ходе исследования автор пришел к выводу о том, что данная тема не только обогащала художественное творчество на тему дружбы монголо-советского народов, но и углубляла новый образ коммуниста-интернационалиста.

STUDIA MONGOLICA
PERMANENT COMMITTEE
INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Tom. XIII (21) 1985 Fasc. 16

Г. МЭНЭС

ЭРТНИЙ МОНГОЛЧУУДЫН "ТОНОГ АВАХ" ЁСНЫ УУСЭЛ, ХУВЬСЛЫН АСУУДАЛД

"Монголын нууц товчоо"-ны 187-р зүйлд " cisutu tonog abugci", 195-р зүйлд "cisutu tonog tohogcin", "nd tonog abugcin " гэсэн гурван сонирхолтой хэллэг бий. "Монголын нууц товчоо"-г судалж орчуулсан А. Палладий, Л. Лигети, Э. Хэниш, П. Поуха зэрэг эрдэмтэд эдгээр хэллэгийг дайсны баатрын цуст хувцас хунар, эд юмсыг булаан дээрэмдэгч гэсэн утгаар ухаарч орчуулсан байна (8, 78-82-р тал).

Эрдэмтэн Ш. Гаадамба энэ гурван хэллэгийг судлаад, "балар эртний монголчуудын дунд баатар эр дайн тулалдаанд дайснаа дарвал ялж дийлсний баримт нотолгоо болгож алагдсан дайсны биеэс (чих, хуруу, толгойн хүйх зэрэг) ямар нэг хэсгийг нь огтолж буюу өвчин авдаг заншилтай байсныг заасан үгс болов уу" гэсэн санаа дэвшүүлээд, "дайснаа ялж дийлсэний баримт болгож хүйхтай ус, гэзэг, эсвэл гэзэгний боодог зэргийг авдаг заншилтай монголчуудад" байсныг сурвалж бичиг, аман зохиол судал гааны хэрэглэгдэхүүнээр тодруулсан байна. Тэгээд Ш. Гаадамба энэхүү гурван хэллэгийн утга санааг хянан үзээд, "хүйх арьсыг нь хуулж тонож авдаг гэсэн утгатай гэвэл хувцасыг тайлан авдаг гэснээс илүү тохиромоор байна" гэжээ (8, 84, 85, 90-р тал). Судлаач цааш нь" адуу идээ, иргэн өргөныг дээрэмдэж талсан тухай яриндаа ер нь "чисуту тоног тоноху", "үб тонаг абуху" гэх мэтээр хэлсэн нь "Нууц товчоонд" тааралдахгүй байгааг анхаарууллаад, "дайн байлдааны үес олз ашигт шунаж саатан төдөхийг тэр үед буруушаан хориглодог байсан"тухай тодорхой мэдээ гаргаж зажээ (8, 85-88-р тал).

Хэлний шинжээч Ц. Шагдарсүрэн "Монголын нууц товчоо"-ны "тоног" гэдэг угийг тусгайлан авч үзээд, "монгол болон төрөл бусад хэлнээ "тоног" гэдэг уг зөвхөн юмны хэрэгсэл, зэмсэг, хувцас гэсэн утгатай л тохиолдож байна. . . "тоног" гэдэг уг бүр эрт "тонож явсан юм, дээрэмдэж авсан юм, хэрэг болгож авсан юм" гэсэн утгатай байснаа үгийн утга баяжих, хомсдохын ёсоор "хувцас хунар, эд агуурс, зуулт чимэг, хэрэгсэл" гэсэн утгатай болж мөн утгаараа "Монголын нууц товчоо"-нд явж байгаа бололтой" гэсэн дүгнэлтэнд хүрсэн бөгөөд хэлний хэрэглэгдэхүүн болоод монголчууд ялсан дайсныхаа цустай хувцасыг тайлан авдаг байсан тухай судар бичгийн мэдээнд үндэслэн "дайн тулаанд ялсан хүн дийлсний тэмдэг болгож дийлдсэнийхээ цуст хувцсыг тайлан авч ганзагалдаг. . . гэхэд болохгүй газаргүй юм" гэсэн санал тавьсан байна (24, 318-р тал).

Судлаач Х. Сампилдэндэв эл гурван хэллэгийн утга санааг дахин хянаж үзээд, "Монголын нууц товчоо"-нд эл уг "cisutu tonog,ub tonag" гэсэн хоёр янзаар, өөр өөр угстэй хоршин гарч буй бөгөөд тоног гэдэг угийн бичлэг ч гэсэн хоёр өөр буйг анхаарахгүй байж болохгүй. . . ер нь ч өгүүлбэрийн утгаас үзвэл цуст тоног гэдэг нь алагдсан дайсны хувцас хунар, өв тоног гэдэг нь толгойн хүйх гэсэн өөр өөр утгатай байж болох байна. Иймд тоног авах ёс нь зөвхөн хувцас хунар авах гэсэн өрөөсгөл утгаар бус, аль алиныг нь багтаасан өргөн дэлгэр

ашуулгатай байж болох юм" гэсэн санал гаргажээ (19, 167–168-р тал).

Эдгээр эрдэмтэдийн судалгаанаас үзэхэд, эртний монголчууд дийлдсэн дайсны бие эрхтний аль нэг хэсгээс нь тонон авдаг, цустай хувцас юмсыг мултлан авдаг байсан нь угтаа нэгэн ёсны илэрч буй хоёр хэлбэр уу? ерөөс хоёр өөр ёс уу? гэдэг талаар санал зөрөөтэй байгаа нь харагдаж байна. Бид Х. Сампилдэндэвийн саналыг дэмжиж байна. Өөрөөр хэлбэл, эртний монголд ялагч нь ялагдагчийн толгойны хуйх арьс, гэзэг ус, чих зэрэг зүйлсийг тонон авах, эсвэл өмссөн цустай хувцас зэргийг мултлан авах цэрэг дайны нэгэн өвөрмөц ёс байсныг "тоног авах" гэж нэрлэдэг байсан бололтой.

Дээрхи судлаачид монголчуудын "тоног авах" ёсны үүсэл, түүнийг анх гараха ямар хүчин зүйл нөлөөлсөн, нэг үгээр хэлбэл,"тоног авах" ёсон ямар түүхэн нөхцөлд, хэзээ үүсч, хэрхэн хөгжиж хувьссан бэ? гэдэг асууд лыг хөндөөгүй байна.

Алсан дайсныхаа хуйх, гэзэг, чих зэргийг тонож авдаг энэ ёс Төв Азийн нүүдэлчид, туҳайлбал монголчуудын дунд эрт цагт дэлгэр байсан бололтой. Энэ талаар сурвалж бичигт сонирҳолтой мэдээ тааралдаж байна. Эртний монголчуудтай үгсаа гарлын холбоотой кидан нар 947 онд Зүр - чидийн Алтан улсад уулгалан дайрч, алсан хүн бүхний чихийг ялсны тэм - дэг болгон огтлон авч одсон байна (10, 24-р тал). Мөн 508 онд гаоцзю (уйгар) аймгийн Миэту жанжин Пулэйҳай хэмээх нуурын хойд биед жүжаны цэргийг бут цохиж, тэдний жанжин Футу-гийн толгойн үсийг хярган авч байжээ (13, 405-р тал). Бас 87 онд сяньби аймаг умард хүн - хүгийн нутагт довтлон тулалдаж, Юлю шаньюй-гийн арьсыг хуулан авсан тухай мэдээ тэмдэглэгджээ (3,127-р тал).

Сурвалж бичигт буй дээрхи баримтуудыг монгол ардын баатарлаг туулийн мэдээ ч давхар нотолж байна. Халх ардын "Эрийн сайн Эринчин мэргэн хүү" гэдэг туулийн гол баатар нь эсрэг дайсныг төлөөлсөн үнсэн зүстэй бухыг толгой руу нь харваж алсны дараа:

"Зулах духын арьс
Зүзаан ястай байдаг
Эртэй зэлтэй байдаг гээд
Эвэртэй нь аваад хавчуулчиҳжээ" (21,106-р тал).

Мөн баруун Монголын нэг туульд, Шар Бодон өөрийн өрсөлдөгч Эрхэм Хар баатрыг дийлээд, арьсыг чинь авна гэж хэлж байна (15, 246-р тал).

Тэгэхээр эндээс, монголчууд алсан дайсныхаа толгойноос зөвхөн хуйх арьс, гэзэг ус, чих зэрэг тодорхой хэдэн хэсгийг хэрэг болгон авдагийн учир юу вэ?, дэлхийн бусад ард түмэнд иймэ ёс байсан уу? гэдэг асуулт аяндаа гарч байна. "Тоног авах" ёс маш эртний уламжлалтай бөгөөд дэлхийн олон овог аймгийн дунд түгээмэл байсны улбаа мөр ч үлдэж ирсэн байна. Алсан дайсны хуйх арьсыг авдаг ёс байсан ханты-манси ардын баатарлагийн домогт олонтоо гардаг байна. Үүнээс гадна, тэдний үндэсний наадам цэнгээнд оролцогсод хоёр хэсэг болон хуваагдаж тэмцэлдээд, ялсан нь ялагдсаныхаа хуйх авч байгаа мэтээр толгойд нь хүтгэ хүргээд, үсийг нь авч буй дүр үзүүлэн өвс зулгаан авсны дараа, "би түүнийг алаад, толгойн арьсыг нь хуулан авлаа" гэж хэлдэг байна (23, 115-р тал). Осетин ардын баатарлаг туульд, тэд алсан дайсныхаа хуйх хуулан авч байсан тухай мэдээ тааралдаж байна (9, 44-р тал). Тэрчлэн герман, слав болон европын олон овог аймгийн ардын аман зохиолд,толгой цавчих, хуйх авах ёс тусгагдсаныг оросын судлаач Л. Ф. Воеводский тэмдэглэжээ (5). Алсан дайсны хуйх арьсыг (скальп) хуулан авдаг энэ ёс бас Умард Америкийн зөвхөн зүүн урд хэсгийн болон ирокез овгийн

индианчуудын дунд ч байсан бөгөөд ХҮШ зуунаасе европын колоничлол эҳэлсэн үед бусад аймгуудад нь дэлгэрсэн байна. Индианчуудын энэхүү цэрэг дайны ёсыг зөвлөлтийн эрдэмтэн С. А. Токарев судлаад, дайчин эр алсан дайсныҳаа амин сүнсийг нь эзэмдэж, түүнийг үргэлж өөртөө хадгалах үзлийн үүднээс тэгж толгойн хуйх арьсыг тонон авдаг бололтой гэжээ. (20, 130-р тал).

Дээрхи баримт, эрдэмтэдийн судалгаанаас үзэхэд, "тоног авах" ёс нь дээр үед дэлхийн олон ард түмний дунд түгээмэл байгаад, хожим мартагдсан нь тодорхой байна. Харин энэ ёс хээзээ, хэрхэн үүссэнийг энэ хэр тусгайлан судлаагүй байна.

Иймд бид энэ өгүүлэлдээ монголчуудын дунд "тоног авах" ёс хэрхэн үүсч хөгжсөн тухай саналаа гаргах зорилт тавилаа. Эртний монголчуудын "тоног авах" ёс нь балар эрт цагт үүссэн амьтны үзүлдийг эрхэмлэх, түүнийг авах зан үйлээс урган гарсан бололтой. Судлаач Ш. Гаадамба "Зүлд гэдэг, алагдсан амьтны үүшги зүрхийг улаан цагаан хоолойн дагуу цээжний хөндийн нүхээр сугалан, толгойтой нь хамтаар авсныг бүхэлд нь зүлд гэдэг байна. Заримдаа толгойн оронд хэл багалзуурыг, зүрх үүшгитай нь хамтаар нь авсныг зүлд гэж нэрлэх явдал одоогийн монгол оронд үзэгддэг" гэж тодорхойлсон байна (7,36-37-р тал).

Хүн болон амьтны толгой, үүшги, зүрх, голт зэргийг онцгойлон үздэг үзэл санаа монгол ардын баатарлаг туульд нэлээд тодорхой тусчээ. Жишээлбэл, халх ардын "Эрийн сайн Хан Харангуй" гэдэг туульд:

"Хадан чингэл Хар Баатар
Гурван настай Улаадай мэргэнийг
Гол зүрх руу харавтал
Амь гол нь тасарчээ" гэж гарч байгаа нь хүний амь голыг зүрхтэй холбон үзэх санааг илтгэжээ (21, 53-р тал). "Эрийн сайн Эринчин мэргэн хүү" гэдэг туулийн гол баатар нь Хар Хул хааны Асар Басар ноход нь дайраад ирэхэд:

"Үүшиг зүрхийг ноогдуулан
Утсан голоор нь хатгаад" алсан байна (21, 109-р тал).

"Эзэн тэнгэр хаан" гэдэг туульд Алиа Цэмбэл баатрын Гурван настай Гунан будуун хүүгийн дүү хоёр настай Хошуучай хүү:

"Онио мэргэн хулгайчийг
Үушиг зүрхийг нь
Бяц дарж алсан гэнэ" (16, 114-р тал).

"Эрдэнэ хавхан соёо" туулийн баатар арван таван толгойтой атгаалжин хар мангастай тулалдаж:

Сунадаг цагаан илдийг
Суга татан авч
Арван таван толгойг нь
Тариа шиг хадаж
Ханан чинээ хавиргы нь
Хадан хадан хаялж
Хар голт зүрхийг нь
Зүсэн зүсэн огтолж
Тэг дундуур нь цавчаад" аюултай дайснаа дарсан байна

(21, 192-р тал). Өмнө эш татсан туулиудад эсрэг дайсны зүрх уушгийг хатгаж алсан бол энэ туульд мангасын толгойг, дараа нь зүрхийг цавчин амийг хороосон нь сонин юм.

Ардын аман зохиолын эдгээр мэдээнээс үзвэл, эрт үед монголчууд хүн болон аливаа амьтны амин гол нь толгой, зүрх, голт уушги зэрэг хэдэн тодорхой эрхтэнд оршдог хэмээн үздэг байжээ. Үүнээс гадна бас цусыг амьтай холбож ойлгодог байсан байна. Жишээлбэл, буриад ардын туульд Аламжи мэргэн гэгч баатар үхсэн гурван хүний толгой дээр өөрийн баруун гарын чигчий хуруугаа цусыг дусааж амилуулдаг (25, 39-р тал). Бас буриадын угсаатан судлаач М. Н. Хангалов, бөө хүн угаалга хийхийн өмнө өөрийн хэрэглэх гэж буй таяг, хуур, хэнгэрэг, толь хувцас зэргийг цусаар будаад бөгөөд үүнийг "амилуулах" гэж нэрлэдэг байсныг тэмдэглэсэн байна (22, 1 боть, 379-р тал). Мөн заримдаа бөөгийн тоногийг цусаар биш, өөр зүйлээр орлуулан амилуулах зан үйл гүйцэтгэдэг байжээ. Жишээлбэл, дархадын бөө хэнгэрэг амилуулахдаа түүний жолоог улаан өнгөтэй утасны хамт барьдаг байна (2, 221-р тал). Энэ зан үйл-тэй холбогдуулан тэмдэглэхэд буриадууд бөөгийн "майхабши" гэдэг тем-реер хийсэн бугын эвэртэй малгайг амилуулахдаа, түүний дээр амьт-ны уушгийг тавьдаг байсан нь сонин юм (14,293-р тал).

Амилуулдаг энэхүү зан үйл нь бөө мөргөлийн уламжлалтай Сибирийн олон ястанд дэлгэр байжээ. XIX зууны үед Якутад бөө бөөлөх хүн мөн хувцас, хэнгэрэг, ялангуяа хэнгэрэг дээр зурсан хүн, амьтан, шу-вууны дүрсийг малын цусаар буддаг байжээ. Тэр ч байтугай бөөгийн хувцасны бүх төмөр тоногийг төмрийн дархан хийж дуусгаад, заавал тус-гай бэлтгэсэн малын цусанд дүрдэг байжээ. (4, 2-р тал, 18, 65-р тал) Орчон (эвенкүүд) нар бөөгийн хэнгэрэгийг амилуулахдаа, цагаан зүсмийн буга алж, арьсыг нь толгой шийрийн хамт нар мандах зүг рүү харуулан өлгөөд, цусаар нь хэнгэрэгээ буддаг аж (12, 82-р тал).

Эдгээр мэдээнээс үзвэл, эртний нүүдэлчид, анчид цусыг амин сунс-тэй холбон ойлгож, амь нь цусанд бас хадгалагдаж, түүгээр дамжин бу-сад зүйлийг амилуулдаг гэж ухаардаг байсан бололтой. Тэгэхээр эртний хүмүүс хүн болоод амьтны амин сунс нь толгой, голт зүрх, уушги зэ-рэг хэдэн тодорхой эрхтэнд, өөрөөр хэлбэл зүлд, зүлдэнд ордог эдгээр эрхтэнгүүдийг холбогч цусанд оршдог байна гэж ойлгодог байжээ.

Зүлд авах үйл нь тэгэхээр амьтны хамгийн эрхэм зүйл, амин сун-сийг эзэмдэн авах гэсэн эрмэлзлээс анх үүссэн бололтой. Зүлд авах энэхүү зан үйл нь монголчуудын ан агнуурын салбарт нэлээд хатуу мөр-дөгдөж ирсэн байна. Угсаатны зүйч К. В. Вяткина, анчин хүн амьтан алаад түүний толгой, багалзуурыг зүрхний хамт; заавал авдаг буюу тэр зүлдийг эзэмдэн анчны гэр бүлийнхэн иддэг заншил байсан тухай дурдаад, бас анчин өөр хүний буугаар ан хийсэн бол алсан амьтныхаа зүлдийг заа-вал буунд эзэнд өгдөг ёс байсныг тодруулан бичсэн нь сонин (6, 242-р тал). Эртний монголд анчин хүн амьтны махыг хүнд өгдөг боловч зүл-дийг арьсны хамт өөртөө заавал авч үлддэг заншил нь "Монголын нууц товчоо"-ны 13-р зүйлд тэмдэглэгдсэн байна.

Ангийн зүйлдийг алсан анчин авдаг байснаас гадна тэр зүлдийг ихэд эрхэмлэн үздэгийн улбаа мөр буриадын "дээш барих" гэдэг нэртэй-гээр хадгалагджээ. Буриадууд баавгай алж зүлдийг авч чанаж идсэ-ний дараа толгойн ясыг уушги, зүрхний ялихгүй хэсгийн хамт хус мод-

ны дээр тавиад, мөчрөөр нь ороон орхидог ажээ (22, II боть 54-55-р тал).

Монголчуудын зүлдлэх, зүлд авах зан үйл нь бүр чулуун зэвсгийн үеэс улбаатай байсан бололтой. Чойбалсан хотоос зүүн тийш 40 км га-зарт буй Хэрлэн голын урд эргийн Дунгэлжийн уулын дэргэдэх шинэ чулуун зэвсгийн үеийн (неолит м. э. ө. 5-4 мянган жил) буудлыг хайгуул судалгаанд бэлтгэж зассан нүхэнд бухын толгойн эвэртэй ясыг тавьсан байсныг 1970 онд археологичид илрүүлэн олсон юм. Амьтны толгойг эрхэмлэж, тахиглах заншил неолитын үед монгол оронд дэлгэр байсныг ака-демич А. П. Окладников тэмдэглээд, Дорнод Монголын Тамцаг булгийн буудлыг дэргэд мөн гурван бухын толгойн яс, Онон голын өндөр эрэг дээр зэрлэг адууны толгойн яс, Ар Байгалийн Лена мөрний эрэг дээр гөрөөс-ний толгойг тусгай нүхэнд тавьсан байсан тухай өгүүлжээ (17, 199-202 р тал)

Ангийн зүлдийг авдаг, түүнийг эрхэмлэн тахидаг зан үйл нь гол амь зүүлгэ нь ан агнуур байсан тэр эрт цагт аж ахуйнх нь онцлогтой холбоо-тойгоор буй болжээ. Зүлд авах зан үйл нь угтаа бөөгийн мөргөл төлөв-шин тогтохоос өмнөх үеийн хүний орчлонгийн мөнх буюу мөнх бусын ту-хай ойлголтыг танин мэдэх гэсэн сэтгэлгээний үндсэн дээр үүссэн байна. Өөрөөр хэлбэл, тэр эрт цагийн анчин хүн ан гөрөө элбэг дэлбэг байл-гах, ан амьтны амин сүнсийг эзэмдэхийг чухал үзэж зүлдийг нь зөвхөн өөрөө авдаг, бусдад өгдөггүй болсон байна. Түүгээр ул барам зүлдийг хүндэтгэн тахилга тайлгад ч хэрэглэдэг болжээ. Тэгээд ч хожим хүртэл монголчууд алсан ангийнхаа зүлдийг өөр хүнд өгвөл ангийн аз харина гэж түүнийг өөрөө авдаг байсан ажээ (7, 36-37-р тал).

Зүлд авах зан үйл үүсч дэлгэрсэн тухай эдгээр баримт, саналууд нь эртний монголчуудын "тоног авах" ёсны үүсэл хөгжил, утга учрыг тодруу-лахад зохих ач холбогдолтой гэж бид үзэж байна. Учир нь, эрт үед баа-тар эр дайснаа дийлээд зогсохгүй мөн өөдтөнгөө энэ ертөнцөд дахин сэ-хээ авахуулахгүйн тулд түүний амин сүнсийг эзэмдэн авч өөртөө үлдээ-хийг чухалд үзэж, алж дарсныхаа дараа заавал "тоног авах" ёс гүйцэт-гэдэг байсан бололтой. Ийм ч учраас баатар эр тулаанд дийлэгдсэнч өө-рийн бие, биеийн аль нэг хэсгийг дайсанд тоног болгон авахуулахыг ихэд болгоомжлон цээрлэдэг байжээ. Жишээлбэл, монгол нутагт бичиж авсан Жангарын туулийн "Гунан бодон хүү" гэдэг бүлэгт хөөр настай Хошоодхон хүү өөрийн өөдтөн болсон Хатайр мэргэн хааны хүү Хар Бавгар баатар гэдгийг дийлээд алахын өмнө түүний үгийг асуухад:

"Одоо цаг түүх минь
Нэгэнт болсон тул
Хүрэн улаан элгийг минь
Битгий эмтлэн алаарай
Хүнд хар махыг минь
Битгий хэрчин алаарай
Гүн хар нүдийг минь
Битгий сохлона алаарай
Ханхар өргөн цээжийг минь
Битгий хадан эвдээрэй
Хар хүрэн зүрхийг минь
Битгий хагалан зүсээрэй
Үүнээс бусдыг яахыг
Чи өөрөө мэд..." гэж хэлсэн нь сонирхолтой юм.

(1, 104-р тал). Буриад ардын "Аламжи мөрген хубун" гэдэг туулийн гол баатрын морь нь дайсанд хорлогдсон эзнийгээ хайцуйн чинээ бүдүүн гээгнээс нь авч дуугаад, гэрийн зүг эргэн давхиж ирж байна (25,41 -р тал). Энэ бол баатар эр хэдийгээр дайсандаа хорлогдон дийлэгдсэн бо - ловч амин сүнсийг дайсанд алдахгүйн тулд итгэлт хүлэг нь эзнийхээ биеийг гэрт нь авчирч байгаа нь тодорхой. Тийнхүү баатрын амин сүнс нэгэнт дайсны гарт ороогүй учраас дараа нь дүүгийнхээ тусламжаар тэр эр дахин сэргэж байна.

Эртний монголчуудын "тоног авах" энэхүү өвөрмөц ёс нь үүссэ - нээс хойш нэлээд хувьсан хөгжжээ. Уг ёс нь дайн тулалдааны туйхайн байдлаас болж алсан дайсны хүйх арьс, гээг үс, чих зэргийг тоножэсвэл хувцас юмсыг тайлан авах хоёр хэлбэрээр уламжилсан бололтой. Дайн тулалдааны онцгой нөхцөлд тэр болгон алсан амьтны зүлд авдагтай адил дарсан дайсныхаа толгой, уушги, зүрх, багалзуур зэргийг бүхэлд нь сугалан авах нь бэрхтэй болох нь мэдээж. Иймээс учраас баатар эр дийлж ялсан дайсныхаа амин сүнсийг эзэмдэж, энэ ертөнцөд дахин сэхээ авахуулах - гүй бүрэн устгахын тулд түүний амин гол эрхтэнгүүдийг төлөөлүүлэн аль нэг хэсэг, туйхайлбал толгойг тоног болгон авдаг хэлбэр байжээ. Жишээлбэл, халимаг ойрадын Жангарын туулийн "Догшин Шар Гүргүү" гэдэг бүлэгт Гунан Улаан Шовшуурын баатрууд Шулмын хаан Догшин Шар Гүргүү дийлснийг сонсоод: "Манайхан үйлээ бүтээсэн бололтой" гээд

Эгэм эгмээ түшилцээд
Эгшиг дуугаа дулалдаад
Адаглахад хүн бүр
Алагдсан дайсны таван буман толгойг
Ардаа ганзагалаад ирэв" гэж гардаг (11, 202 -р тал). Түүний зэрэгцээ амин гол эрхтэнгүүдийг төлөөлөгч болох толгойг мөн л төлөөлүүлэн түүний аль нэг хэсэг, туйхайлбал байлдааны үед тоноход хялбар хүйх арьс, гээг үс, чих, үсний боодог зэргийг хэрэг болгон авдаг байжээ. Мөн сударт буй мэдээнээс үзвэл дайснаа дийлээд түүний цустай хувцас юмсыг нь тайлан аваад ганзагалдаг байсан нь эргэлзээгүй юм. Эртний монголчууд иймэрхүү хэлбэрээр тоног авдаг байсныг туулийн мэдээ ч батлаж байна. Халимаг ойрадын Жангарын туулийн "Өрчлонгийн сайхан Миньяан хүчтэй хүрмэн хааныг амьдаар хэл барьж ирсэн" бүлэгт Миньяан баатар өөрийн гүйцэж ирж буй Барс мэргэн гэгч дайсны баатрыг хүүхний тусламжтайгаар хоолойгоор нь тас харваж толгойгийн уна - гаж алсны дараа:

"Алтан шаргын жолоог
Зөв эргүүлж ирээд дэргэд нь буув.
Хөө хүягийн нь тайлаад
Махы нь цахиур огтолж түймэрдээд
Уулын чинээн огтор шар цоохор хүлгий нь
Хөтлөөд гарав" гэж гардаг (11. 157-р тал)

Мөн буриад ардын "Айдурай мерген" гэдэг туулийн гол баатрын морь нь дайснаас алагдсан эзнийхээ биеийг биш, харин хувцасыг нь авч гэрийн зүг эргэн давхиж байна (25,51-р тал). Тэгэхдээ эдгээр мэдээ нь алсан дайсны цуст хувцас тонон авдаг, эсвэл алагдсан дайчны хувцасыг өгдөггүй ёсыг зааж байгаа болохоос, түүний утга учрыг тодруулахгүй байна. Энэ учрыг бидний сонирхож буй "Монголын нууц товчоо"-ны гурван хэллэгт хоёр удаа гардаг "цуст" гэдэг үг зааж байгаа бололтой. Дээр өгүүлсэн цус болон цустай холбоотой амилуулах ёсны тухай мэдээнээс үндэслэн бодвол, алагдсан дайсны амин сүнс цусаар дамжин түүний хүч -

цас хунар, хөө хүяг зэрэг өмссөн зүйлд шингэн хадгалагдаж үлддэг гэж эртний монголчууд үздэг байсан бололтой. Иймд эртний монголчууд дийлсэн дайсныхаа заавал цус болсон хувцас, хөө хүяг болон бусад өмсөж эзэмсэн зүйлийг тоног болгон авдаг болжээ гэлтэй. "Тоног авах" ёсны энэ хэлбэртэй холбогдуулан тэмдэглэхэд, Чингис хаанаас Жамуха "Асгарах цусыг гаргалгүй алуулж өршөө намайг!" гэж гуйсан нь учиртай билээ(26, 201-р зүйл).

Туульд гарч буй дээрхи мэдээ баримтуудаас үзвэл эртний монголчууд "тоног авах" ёсны дагуу дайсныхаа биеийг хөндөж,амин голыг таслаж, түүний аль нэг хэсгийг авдаг байсан нь үнэн бөгөөд эдгээр амин сүнс агуулсан эрхтэнгүүдийг зарим туульд "зүлд" гэж хэлж байгаа нь уг ёсны үүслийг зааж байгаа бололтой. Жангарын туулийн "Хонгор гэрлэсэн" бүлэгт Арслангийн Араг Улаан Хонгор Тэнгэрийн Төгөө Бүс баатрыг дийлээд голыг сугалан авсан бөгөөд туульд тэр голыг зүлд гэж нэрлэлээ (11, 38-р тал).

Дээр өгүүлсэн зүйлийг хураангуйлан дүгнэхэд, ан амьтны зүлд авдаг зан үйл мал аж ахуй буй болохоос өмнө үүссэн бөгөөд уламжлал улбаа нь XX зууны эхэн хүртэл ямар нэгэн хэлбэрээр хадгалагдсаар иржээ. Ан аж ахуйн шүтлэгийн салшгүй нэг хэсэг болох зүлд авах ёсноос салбарлан гарсан "тоног авах" ёс нь монголчууд эцгийн эрхт ёсонд шилжих үед үүсээд, овог аймгуудын хооронд тасралтгүй дайн байлдаан болдог байсан цэргийн ардчилал, эртний улсуудын үед улмаар цэцэглэсэн байна. Харин монголд феодалын харилцаа хөгжиж, феодалжих явц гүнзгийрэх үеэс эхлэн "тоног авах" ёс аажмаар буурч мартагдах тийшээ ханд сан бололтой байна.

НОМ ЗОХИОЛ

1. Аянан Алдарт Аялган Хонгор. БНМАУ-аас- сурвалжлан бичсэн Жангарын туулиас. Удиртгал ба тайлбар сэлт үйлдэж хэвлэлд бэлтгэсэн Ц. Загдсүрэн. -"Аман зохиол судлал". XI боть, 1 дэвтэр, УБ. ,1978
2. Бадамхаган С. Хөвсгөлийн дархад ястан. УБ. 1965.
3. Бичурин Н. Я. (Иакинф) Собрание сведений о народах, обитавших в Средней Азии в древние времена. Т. 1. М. -Л. ,1950.
4. Васильев В. Н. Шаманский костюм и бубен у якутов. -"Сборник музея антропологии и этнографии" Т. VШ, СПб. , 1910.
5. Воеводский Л. Ф. Чаши из человеческих черепов и тому подобные примеры утилизации трупа. -"Записки Новороссийского университета" Т. 24, Одесса,1878.
6. Вяткина К. В. Монголы Монгольской Народной Республики. -"Восточно-азиатский этнографический сборник, 1", Труды Института этнографии, новая серия. Т. 60, М. -Л. , 1960.
7. Гаадамба Ш. "Нөкөр сиролга-да" гэдэг үгийн учирт. -"Монголын судлалын зарим асуудал", Ш боть, 9 дэвтэр. УБ. 1961
8. Гаадамба Ш. "Тоног" гэдэг үгийн учир. -"Нууц товчооны нууцаас", УБ. , 1976.
9. Дюмезиль Ж. Осетинский эпос и мифология. М. , 1976.
10. Е. Лун-ли. История государства киданей (Цидань го чжи). Перевод с китайского, введение, комментарий и приложения В. С. Таскина. М. , 1979.
11. Жангар. Халимаг хэлнээс монгол хэлэнд буулгасан Т. Дугэрсүрэн УБ. ,1963.

12. Мазин А. И. Традиционные верования и обряды эвенков-орочонов. Новосибирск, 1984.

13. Материалы по истории древних коневых народов группы дунху. Введение, перевод и комментарий В. С. Таскина. М., 1984.

14. Михайлов М. Т. Анимистические представления бурят. -В. кн.: "Природа и человек в религиозных представлениях народов Сибири и Севера. Л. 1976.

15. Монголо-ойратский героический эпос. Перевод, вступительная статья и примечания Б. Я. Владимирцова. Пб. -М., 1923.

16. Монгол ардын тууль. УБ., 1982.

17. Окладников А. П. Из области духовной культуры неолитических племен долины Керулен: ритуальные захоронения остатков животных. -В кн.: "Археология и этнография Монголии", Новосибирск. 1978.

18. Припузов Н. Сведения для изучения шаманства у якутов Якутского округа. -"Известия Восточно-Сибирского отдела Русского географического общества", Т. VX, №3-4, Иркутск. 1884.

19. Сампилдэндэв Х. "Тоног авах" ёсны талаар тодруулмаар зарим зүйл. -"Аман зохиол судлал", Х боть, 12 дэвтэр, УБ.,1977.

20. Токарев С. А. Религия в истории народов мира. М., 1976.

21. Халх ардын тууль. УБ. 1967.

22. Хангалов М. Н. Собрание сочинений Т. 1-Ш, Улан-Удэ. 1958-1960

23. Чернецов В. Н. Вогульские сказки, - "Сборник фольклора народа манси", Л., 1935.

24. Шагдарсурэн Ц. "Монголын нууц товчоо"-ны "тоног" гэдэг үгийн тухай. -"Хэл зохиол судлал". УШ боть 9 дэвтэр, УБ., 1970.

25. Эхирит-булагатские эпопеи "Пятнадцатилетний Айдурай Мерген и его сестра Агу Гохон", "Аламжи Мерген хубун и сестрица Агуй Гохон Духэй". Буриад хэлнээс орос хэлэнд буулгасан Ц. Жамцарано. -"Studia folclorica" 1 боть, 2 дэвтэр, УБ., 1959.

26. Index to The Secret History of the Mongols. By Igor de Rachewiltz. Published by Indian univirsity, Bloomington.

Г. МЭНЭС

О ГЕНЕЗИСЕ И ЭВОЛЮЦИИ ОБЫЧАЯ СКАЛЬПИРОВАНИЯ У СРЕДНЕВЕКОВЫХ МОНГОЛОВ

В настоящей статье предпринята попытка раскрыть культурно-исторический исток и на этой основе проследить трансформацию формы и содержания обычая скальпирования у средневековых монголов, существование которой подтверждается работами исследователей. Анализ сведений из героического эпоса монгольских народов, наряду с привлечением данных письменных источников, этнографии и археологии, достаточно четко указывают,что идейные истоки этого обычая органически связывается с промысловым культом первобытного общества, в частности с обрядом отделения и почитания жизненно важных органов и убитых на охоте животных, каковым являлись голова, сердце, легкие и осердие, и которая в совокупности носила у монголов название "зулд". Анимистические представления этого обряда с господством патриархальных отношений и оформлением строя военной демократии у племен Центральной Азии, послужили идейной основой для возникновения обычая скальпирования. В дальнейшем,с нарастанием роли войны и организацией войны в обществе, архаичный охотничий обряд, не претерпев идейных изменений, трансформировался в отдельный обычай скальпирования поверженного врага, которая осуществлялась в основном двумя путями.

PERMANENT COMMITTEE
INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Tomus XIII (21) Fasc. 1—21

STUDIA MONGOLICA

ULAN-BATOR
1987

PERMANENT COMMITTEE
INTERNATIONAL CONGRESS OF MONGOLISTS

Tomus XIII (21) Fasc. 1 -21

This volume is dedicated to the 5th International Congress of Mongolists

STUDIA MONGOLICA

Editorial Board; Sh.Natsagdorj (Editor -in Chief)
S.Luvsanvandan (Editor)
A.Luvsandendev
N. Ish-jamts
S. Norovsambuu
Ts. Damdinsuren
Sh. Bira

ULAN BATOR

1986

ГАРЧИГ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ӨГҮҮЛЭЛ

Ц. ДАМДИНСҮРЭН. Нэр томъёог судлах хэрэгтэй 3
Ш. ЛУВСАНВАНДАН. Нэр томъёоны тухай асуудалд 6
Д. ЁНДОН. Легенда о Калидасе 8
Д. ЦЭРЭНСОДНОМ. Генеалогическая связь предания о Дуве соҳоре с мифологическим сюжетом об одноглазом великане 13
С. МӨӨМӨӨ. Хавсарга хэл шинжлэлийн онолын зарим асуудалд 25
Н. С. ДИКО. Монголия в жизни и деятельности Н. К. Рериха и его семьи 30
Б. БАЗЫЛХАН. Специфические особенности Баян-Ульгейского говора Казахского языка 38
Т. СОДНОМДАРГИА. Төвд хэлээрхи логикийн гол сурвалжуудын тухай 42
Л. ХҮРЭЛБААТАР. Төвд, Ганжур, Данжур, түүний монголд дэлгэрсэн нь 47
О. СҮХБААТАР. Монгол бичгийн хэлнээ санскрит үгийг тарнийн дуудлагаар тэмдэглэж ирсэн нь 72
Ч. ДОГСҮРЭН. Монгол газар усны нэр тэмдэглэх болзмол латин цагаан толгой боловсруулах асуудалд 77
Д. ТӨМӨРТОГОО. Монгол хэлний үеийн бүтэц, хувьсал 83
А. ОЧИР, Ж. СЭРЖЭЭ. Орчин цагийн монгол хэлний нэрийн тооны-чууд -чууд бүтээврийн гарлын тухай 92
Л. ТЭРБИШ. Зурхайн илт өгүүлэх нэрийн асуудалд 97
Д. ӨЛЗИЙБАЯР. Аугаа их ялалт, монголын уран зохиол 111
Г. МЭНЭС. Эртний монголчуудын "тоног авах" ёсны үүсэл, хувьслын асуудалд 119

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ МЭДЭЭ

Х. ЛХАГВАСҮРЭН. Дундад зууны үеийн нэгэн булш 129
Р. БЯМБАА. Хэвтээ дөрвөлжин үсгийн шинээр олдсон нэгэн дурсгалын тухай 132
С. БАЯНЦАГААН. Богд зонховоос монголын хаанд бичсэн нэгэн захидлын тухай 150
Ц. ШАГДАРСҮРЭН. Рецензия на книгу А. А. Дарбеевой "Русско-монгольские языковые контакты в условиях двуязычия 155
Б. СУМЬЯАБААТАР. Цуврал бичгээр нийтэлсэн зүйлийн бүртгэл (1977-1982) 158